



2020

**МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ САЛБАРЫН
ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА**



МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ САЛБАРЫН
ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА
2020

Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцоо
үүсэж, хөгжсөний 30 жилийн ойг тохиолдуулан
энэхүү судалгааг гаргав.

АГУУЛГА

1. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2. 2020 ОНЫ БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН РАНК

- Банкны өрсөлдөх чадварын индекс
- Банкны үр ашигт байдлын индекс
- Банкны эрсдлийн индекс
- Гүнзгийрлийн индекс
- Хүртээмжийн индекс
- Макро эрсдлийн индекс
- Хүн амын хөгжлийн индекс
- Улс төрийн орчны индекс
- Мэдээлэл технологийн индекс

3. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН ТАНИЛЦУУЛГА

- Банкны орчин
- Зах зээлийн орчин
- Хүний хөгжил
- Дижитал хөгжил

4. БҮС НУТГИЙН ШИНЖИЛГЭЭ

5. УЛС ОРНУУДЫН ОРЛОГЫН ТҮВШНЭЭР ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

6	6. МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ХААНА ЯВНА ВЭ?	12
7	• Банкны өрсөлдөх чадварын индекс / Монгол Улсын эзэлсэн байр/	12
7	• Макро хүчин зүйлийг хасаж тооцсон банкны өрсөлдөх чадварын индекс / Монгол Улсын эзэлсэн байр/	13
7		
8	7. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН БҮРЭЛДЭХҮҮН	14
8	• Банкны өрсөлдөх чадварын индекс	14
8	• Макро эдийн засгийн хүчин зүйлсийг хасаж тооцсон индекс	15
8	• Бүс нутгийн байршлаар харуулсан ангилал	16
8	• Улсуудын орлогын түвшнээр ангилсан байдал	18
9	• Уул уурхайн хамаарал бүхий орнуудын ангилал	20
9	• Банкны үр ашигт байдлын индекс	22
9	• Банкны эрсдлийн индекс	23
9	• Банкны гүнзгийрлийн индекс	24
9	• Банкны хүртээмжийн индекс	26
10	• Макро эрсдлийн индекс	28
11	• Хүн амын хөгжлийн индекс	30
11	• Улс төрийн орчны индекс	32
11	• Мэдээллийн технологийн индекс	34

8. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС ТООЦОХ АРГА, АРГАЧЛАЛ	36	12. БАНКНЫ САЛБАРЫН СҮҮЛИЙН 15 ЖИЛИЙН ХАНДЛАГА	49
• Агрегат индекс тооцох аргачлал	36	• Нийт актив/ДНБ	50
• Дутуу тоон өгөгдлийн тооцоолол	36	• Мөнгөний нийлүүлэлт/ДНБ	50
• Индекс тооцоолох томъёонууд	37	• Өөрийн хөрөнгө/ДНБ	50
9. ИЖИЛ ТӨСТЭЙ ОРНУУДЫН БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ	40	• Зээл/ДНБ	50
• Киргизстан	41	• ЖДҮ-н зээл/ДНБ	50
• Узбекистан	42	• Чанаргүй зээлийн харьцаа	51
• Нигери	43	• Депозит/ДНБ	51
• Филлипин	44	• Хадгаламжийн долларжилт	51
• Камбож	45	• Зээл/депозит	51
10. МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ТОЙМЛОХ НЬ	46	• Өөрийн хөрөнгийн өгөөж	51
• Өрсөлдөх чадварын индекс, эзлэх байраар	46	• Активын өгөөж	52
11. БАНКНЫ САЛБАРЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ	48	• Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	52
• Банкны салбарын түүхэн хөгжил	48	• Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	52
• Банкны дампуурал	48	• Зээл болон хадгаламжийн хүү	52
		• 2008-2019 оны хүүгийн дундаж үзүүлэлт	52

1. ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Манай улсын уул уурхай, хөдөө, аж ахуй, банк, санхүүгийн салбарууд эдийн засгийн голлох хүнд ачааг нуруундаа үүрдэг билээ. Тэр ч үүднээсээ санхүүгийн салбар дундаа банкны салбарт тулгарах асуудлууд их байдаг. Тухайлбал, Монгол Улс хүүгийн түвшин өндөр улсуудын эхний эгнээнд багтдаг. Сүүлийн 8 жилийн дундаж зээлийн хүүгийн түвшнээр дэлхийд 16-р байранд, хадгаламжийн хүүгийн түвшнээр 11-р байранд тус тус бичигдэж байна. Инфляцийн түвшнээр ч мөн адил 12-р байранд бичигджээ. Хамгийн гол асуудал нь хүүгийн түвшин ийнхүү өндөр байгаа нь макро эдийн засгийн орчноос шалтгаалж байна уу? Эсвэл манай банкны салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлт муу байна уу? гэх дараагийн асуултуудад шууд хөтөлж байна. Мэдээж эдгээр асуултуудад хариулт авахын тулд бид уул уурхайд суурилсан эдийн засагтай орнууд, бүс нутгийн орнууд, орлогын түвшин ижил орнуудтай өөрсдийн орны эдийн засаг, банкны салбарыг харьцуулан судлах хэрэгцээ шаардлага үүсэж байгаа юм.

Судалгааны эхний хэсэгт, банкны өрсөлдөх чадварын индексээр түүвэрт сонгогдсон улсуудын ранжийг гаргасан. Тус хэсгээс нэгдсэн индекс, түүний бүрэлдэхүүн болох дэд индексээр улс орнуудын жагсаалтыг харах боломжтой. Түүнчлэн, банкны өрсөлдөх чадварын индекс тооцох арга аргачлал, бүрэлдэхүүн хэсгийн үзүүлэлтийг хэрхэн сонгосныг энэ бүлгээс унших боломжтой. Судалгааны түүврийг сонгохдоо уул уурхайд суурилсан эдийн засагтай (Уул уурхай, металлын үндэсний зөвлөлөөс гаргасан) орнууд, бүс нутгийн орнууд, орлогын түвшин ижил орнуудыг (Дэлхийн банкны ангилал) голчлон авч үзсэн бөгөөд нийтдээ 39 улсыг судалгаанд хамруулсан. Банкны өрсөлдөх чадварын индексээр Монгол Улс нь 39-н улсаас 26-р байранд жагсаж байна. Бүс нутгийн 5 орноос 2-р байр, уул уурхайн хамаарал бүхий 22 орноос 15-р байр, дунджаас доогуур орлоготой 15 улсаас 6-р байрыг тус тус эзэлжээ. Харин банкны өрсөлдөх чадварын индексээс макро орчны хүчин зүйлийг хасаж тооцоход (инфляц, гадаад өрийн үзүүлэлт гэх мэт) үр дүн нэлээд анхаарал татав. Тодруулбал, тус индексээр Монгол Улс 39 улсаас 15-р байр, Бүс нутгийн 5 орноос 1-р байр, уул уурхайн хамаарал бүхий 22 орноос 10-р байр, дунджаас доогуур орлоготой 15 улсаас 2-р байрыг тус тус эзэлжээ. Өөрөөр хэлбэл, макро орчны тогтворгүй байдал манай улсын банкны салбарын өрсөлдөх чадварт хүчтэй нөлөөлж байна. Монгол ч гэлтгүй хөгжиж буй орнуудын хувьд, макро эдийн засгийн тогтворгүй байдал өндөр, улс төрийн орчин таагүй дүр зураг ажиглагдаж байна.

Банкны өрсөлдөх чадварын индексийн дэд бүлгүүд дэх индексийн үзүүлэлтээр Монгол Улс нь банкны салбарын хүртээмж, гүнзгийрлийг илэрхийлэх үзүүлэлтээр харьцангуй дээгүүр бичигдэж байна. Түүнчлэн улс төрийн орчин, хүний хөгжил, мэдээлэл технологийн индексээр эхний 20 байранд багтаж байна. Харин банкны салбарын үр ашиг, эрсдэл, макро эдийн засгийн тогтвортой байдлын индексээр 29-р байрнаас хойш бичигдэж байна. Тус тайланд дэд индекс бүрийн хажуу нүүрэнд тухайн индекс тэй холбогдох үзүүлэлтийг Монгол Улсын

хувьд тодорхойлон авч үзсэн. Тухайлбал, мэдээлэл технологийн индексийн хажуу нүүрнээс та бүхэн дижитал банкны үйлчилгээний талаарх харилцагчийн чиг хандлагыг тодорхойлсон судалгааг унших боломжтой. Судалгааны үр дүнгээс Z үеийнхний цахим банк хэрэглэх хүсэл эрмэлзэл, банкны шинэ цахим үйлчилгээг нээлттэйгээр хүлээж авах байдал харьцангуй өндөр байсан.

Тайлангийн дараагийн хэсэгт банкны өрсөлдөх чадварын индексийг тооцоход ашигласан аргачлалыг дэлгэрүүлж авч үзсэн. Тус индексийг тооцоход Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын гаргасан индекс гаргах гарын авлагыг баримталсан болно. Түүнээс гадна, индекст ашиглагдсан 18-н үзүүлэлт нь яагаад банкны өрсөлдөх чадварыг илэрхийлэх талаар онолын тайлбар, тодорхойлолтыг мөн унших боломжтой.

Тустайланд хэд хэдэн онцлог судалгаануудыг багтаасан. Тухайлбал, орлогын түвшин ижил Киргизстан, Узбекистан, Филиппин, Камбож, Нигери зэрэг 5 улсыг сонгон, банкны салбарын орчны судалгааг хийсэн. Судалгааны зарим сонирхолтой үр дүнгээс дурдвал, Нигери улсад газар нутгийн онцлогоос шалтгаалан сүлжээ бага барьдагтай холбоотой дижитал шилжилт хийхэд саад болж байгаа бол Узбекистан улс дөнгөж 2016 оноос хойш банкны салбараа төрийн захиргаадальтаас чөлөөлж реформ хийж эхлээд байна. Харин Камбож улс ядуурлын түвшнээс гарахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь банкны салбарын үйлчилгээ бичил санхүүд хүрсэнтэй холбоотой байв. Филиппин улсад орлогын түвшин ижил орнуудтай харьцуулахад дижитал шилжилт харьцангуй хурдтай хийгдэж байна. Гэсэн хэдий ч хүн амын 60 хувь нь интернэтэд холбогдоогүйгээс асуудал ихээр тулгарч байна.

Дараагийн онцлох хэсэгт Монгол Улсын өрсөлдөх чадварыг тоймлон авч үзсэн. Тус шинжилгээнд, Дэлхийн эдийн засгийн форумын гаргадаг өрсөлдөх чадварын индексийг ашигласан. Монгол Улс нь сүүлийн 12 жилд дэлхийн 140 орчим улсаас өрсөлдөх чадварын индексээр 90-р байрнаас хойш бичигдэж байв. Тус индексээр сүүл мушгихад хүргэсэн голлох хүчин зүйл нь макро эдийн засгийн тогтворгүй байдал, гадаад өрийн дарамт, хөрөнгийн зах зээл хөгжөөгүй зэрэг нь нөлөөлжээ. Энэ нь бидний тооцсон индексийн хандлагатай ч таарч байгаа юм. Банкны өрсөлдөх чадварын индексийг манай эдийн засгийн тогтворгүй орчин хамгийн ихээр доош татаж байв. Түүнчлэн өрсөлдөх чадвараараа дунджаас доогуур буюу ижил түвшний орлоготой улсуудтай харьцуулахад мөн л хойгуур бичигдэж байгаа юм.

Сүүлийн онцлох судалгаа нь банкны салбарын сүүлийн 15 жилийн хөгжлийн хандлагыг тайлбарласан. Тус судалгаанаас банкны салбарын хүртээмж, зуучлал нэмэгдэж байгаа, зээлийн хүү тасралтгүй буурах хандлагатай байгаа, чанаргүй зээлийн үзүүлэлтэд өөрчлөлт гарахгүй байгаа гэх мэт олон үр дүнг харах боломжтой.

2. 2020 ОНЫ БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН РАНК

Банкны өрсөлдөх чадвар нь банкны үр ашиг, эрсдэл болон санхүүгийн зуучлал, хүртээмж зэрэг салбарын дотоод хүчин зүйлсээс хамаарахаас гадна макро эдийн засгийн тогтвортой байдал, улс төрийн орчин, хүний болон техник, технологийн хөгжил зэрэг гадаад хүчин зүйлсээс мөн шалтгаална. Эдгээр хүчин зүйлс ямар байхаас хамаарч банкны салбарын хөгжих орон зай бий болж, өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.

1. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Саудын Араб
	2	Австрали
	3	Колумб
	4	Канад
	5	Арабын нэгдсэн Эмират улс
	6	Катар
	7	Бүгд Найрамдах Доминик улс
	8	Перу
	9	Бразил
	10	Оросын Холбооны Улс
	11	Ботсвана
	12	Армен
	13	Индонези
	14	Чили
	15	Турк
	16	Узбекистан
	17	Унгар
	18	Боливи
	19	Марокко
	20	Өмнөд Африк
	21	Гана
	22	Мексик
	23	Намиби
	24	Зимбабве
	25	Вьетнам
	26	Монгол
	27	Мадагаскар
	28	Хятад
	29	Филиппин
	30	Киргизстан
	31	Казахстан
	32	Тажикстан
	33	Сенегал
	34	Энэтхэг
	35	Украин
	36	Камерун
	37	Пакистан
	38	Судан
	39	Ардчилсан Конго улс

2. БАНКНЫ ҮР АШИГТ БАЙДЛЫН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Мадагаскар
	2	Зимбабве
	3	Узбекистан
	4	Перу
	5	Гана
	6	Намиби
	7	Бүгд Найрамдах Доминик улс
	8	Бразил
	9	Мексик
	10	Колумб
	11	Судан
	12	Камерун
	13	Турк
	14	Ботсвана
	15	Индонези
	16	Тажикстан
	17	Өмнөд Африк
	18	Боливи
	19	Сенегал
	20	Унгар
	21	Пакистан
	22	Саудын Араб
	23	Киргизстан
	24	Филиппин
	25	Марокко
	26	Австрали
	27	Ардчилсан Конго улс
	28	Чили
	29	Катар
	30	Оросын Холбооны Улс
	31	Монгол
	32	Украин
	33	Вьетнам
	34	Хятад
	35	Канад
	36	Армен
	37	Энэтхэг
	38	Арабын нэгдсэн Эмират улс
	39	Казахстан

3. БАНКНЫ ЭРСДЛИЙН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Саудын Араб
	2	Перу
	3	Бүгд Найрамдах Доминик улс
	4	Киргизстан
	5	Зимбабве
	6	Индонези
	7	Филиппин
	8	Узбекистан
	9	Тажикстан
	10	Гана
	11	Армен
	12	Арабын нэгдсэн Эмират улс
	13	Бразил
	14	Украин
	15	Казахстан
	16	Ботсвана
	17	Судан
	18	Колумб
	19	Вьетнам
	20	Боливи
	21	Мексик
	22	Мадагаскар
	23	Турк
	24	Унгар
	25	Чили
	26	Канад
	27	Ардчилсан Конго улс
	28	Камерун
	29	Монгол
	30	Оросын Холбооны Улс
	31	Намиби
	32	Катар
	33	Австрали
	34	Сенегал
	35	Хятад
	36	Өмнөд Африк
	37	Пакистан
	38	Энэтхэг
	39	Марокко

- Европ болон Австрали
- Хойд болон Өмнөд Америк
- Ойрх Дорнод ба Хойд Африк
- Зүүн Ази ба Номхон далай
- Төв ба Өмнөд Ази
- Сахарын Өмнөд Африк

* Банкуудын өрсөлдөх чадварын индекс нь дотроо 8 багана индекс, 18 үзүүлэлтийг агуулж байна.

** Эдгээр үзүүлэлт нь богино хугацааны банкны өрсөлдөх чадварыг илтгэх ба эдгээр нь жилийн давтамжтайгаар өөрчлөгдөж болно.

*** Банкны үр ашгийн индексийг тооцохдоо татварын өмнөх орлогоор тооцсон нь тухайн улсын татварын хууль, эрх зүйн онцлогийг тусгаагүй, зөвхөн банкны үр ашигт байдлыг илэрхийлэхийг зорив.

4. ГҮНЗГИЙРЛИЙН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Канад
	2	Хятад
	3	Вьетнам
	4	Австрали
	5	Катар
	6	Чили
	7	Арабын нэгдсэн Эмират улс
	8	Өмнөд Африк
	9	Боливи
	10	Марокко
	11	Бразил
	12	Турк
	13	Намиби
	14	Армен
	15	Саудын Араб
	16	Оросын Холбооны Улс
	17	Зимбабве
	18	Колумб
	19	Энэтхэг
	20	Монгол
	21	Филиппин
	22	Перу
	23	Унгар
	24	Ботсвана
	25	Индонези
	26	Узбекистан
	27	Сенегал
	28	Мексик
	29	Бүгд Найрамдах Доминик улс
	30	Киргизстан
	31	Украин
	32	Казахстан
	33	Пакистан
	34	Камерун
	35	Судан
	36	Мадагаскар
	37	Гана
	38	Тажикистан
	39	Ардчилсан Конго улс

5. ХҮРТЭЭМЖИЙН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Монгол
	2	Оросын Холбооны Улс
	3	Марокко
	4	Канад
	5	Армен
	6	Колумб
	7	Боливи
	8	Австрали
	9	Узбекистан
	10	Унгар
	11	Намиби
	12	Турк
	13	Индонези
	14	Бразил
	15	Пакистан
	16	Өмнөд Африк
	17	Саудын Араб
	18	Тажикистан
	19	Чили
	20	Бүгд Найрамдах Доминик улс
	21	Гана
	22	Катар
	23	Арабын нэгдсэн Эмират улс
	24	Мадагаскар
	25	Энэтхэг
	26	Мексик
	27	Киргизстан
	28	Перу
	29	Хятад
	30	Сенегал
	31	Судан
	32	Казахстан
	33	Ботсвана
	34	Филиппин
	35	Камерун
	36	Зимбабве
	37	Вьетнам
	38	Украин
	39	Ардчилсан Конго улс

6. МАКРО ЭРСДЛИЙН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Ботсвана
	2	Катар
	3	Саудын Араб
	4	Филиппин
	5	Хятад
	6	Ардчилсан Конго улс
	7	Энэтхэг
	8	Мадагаскар
	9	Оросын Холбооны Улс
	10	Камерун
	11	Сенегал
	12	Зимбабве
	13	Марокко
	14	Вьетнам
	15	Боливи
	16	Индонези
	17	Бүгд Найрамдах Доминик улс
	18	Перу
	19	Пакистан
	20	Тажикистан
	21	Гана
	22	Мексик
	23	Бразил
	24	Колумб
	25	Чили
	26	Судан
	27	Өмнөд Африк
	28	Намиби
	29	Узбекистан
	30	Канад
	31	Австрали
	32	Армен
	33	Арабын нэгдсэн Эмират улс
	34	Киргизстан
	35	Унгар
	36	Турк
	37	Казахстан
	38	Украин
	39	Монгол

7. ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Катар
	2	Арабын нэгдсэн Эмират улс
	3	Австрали
	4	Канад
	5	Саудын Араб
	6	Унгар
	7	Оросын Холбооны Улс
	8	Чили
	9	Казахстан
	10	Турк
	11	Мексик
	12	Бүгд Найрамдах Доминик улс
	13	Хятад
	14	Колумб
	15	Бразил
	16	Ботсвана
	17	Армен
	18	Перу
	19	Украин
	20	Монгол
	21	Өмнөд Африк
	22	Индонези
	23	Филиппин
	24	Боливи
	25	Узбекистан
	26	Вьетнам
	27	Марокко
	28	Намиби
	29	Киргизстан
	30	Энэтхэг
	31	Тажикистан
	32	Гана
	33	Пакистан
	34	Камерун
	35	Зимбабве
	36	Судан
	37	Сенегал
	38	Мадагаскар
	39	Ардчилсан Конго улс

8. УЛС ТӨРИЙН ОРЧНЫ ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Австрали
	2	Канад
	3	Арабын нэгдсэн Эмират улс
	4	Чили
	5	Унгар
	6	Катар
	7	Казахстан
	8	Хятад
	9	Намиби
	10	Ботсвана
	11	Армен
	12	Саудын Араб
	13	Гана
	14	Өмнөд Африк
	15	Вьетнам
	16	Турк
	17	Марокко
	18	Оросын Холбооны Улс
	19	Сенегал
	20	Перу
	21	Монгол
	22	Колумб
	23	Энэтхэг
	24	Индонези
	25	Узбекистан
	26	Украин
	27	Бразил
	28	Бүгд Найрамдах Доминик улс
	29	Филиппин
	30	Мексик
	31	Киргизстан
	32	Тажикистан
	33	Боливи
	34	Мадагаскар
	35	Зимбабве
	36	Пакистан
	37	Судан
	38	Ардчилсан Конго улс
	39	Камерун

9. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ИНДЕКС

БҮС НУТАГ	БАЙР	УЛС
	1	Арабын нэгдсэн Эмират улс
	2	Катар
	3	Чили
	4	Саудын Араб
	5	Канад
	6	Австрали
	7	Оросын Холбооны Улс
	8	Казахстан
	9	Унгар
	10	Армен
	11	Марокко
	12	Турк
	13	Бразил
	14	Бүгд Найрамдах Доминик улс
	15	Вьетнам
	16	Мексик
	17	Украин
	18	Өмнөд Африк
	19	Колумб
	20	Перу
	21	Хятад
	22	Узбекистан
	23	Ботсвана
	24	Монгол
	25	Гана
	26	Индонези
	27	Киргизстан
	28	Намиби
	29	Филиппин
	30	Боливи
	31	Сенегал
	32	Камерун
	33	Энэтхэг
	34	Зимбабве
	35	Судан
	36	Тажикистан
	37	Пакистан
	38	Ардчилсан Конго улс
	39	Мадагаскар

- Европ болон Австрали
- Хойд болон Өмнөд Америк
- Ойрх Дорнод ба Хойд Африк
- Зүүн Ази ба Номхон далай
- Төв ба Өмнөд Ази
- Сахарын Өмнөд Африк

3. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН ТАНИЛЦУУЛГА

Олон улсын түвшинд банкны өрсөлдөх чадвар, төвлөрлийн талаарх судалгааны ажил их байдаг ч банкны өрсөлдөх чадварын индекс тооцсон судалгаа, товхимол, материал ховор байдаг. Харин олон улсын түвшинд улсуудын өрсөлдөх чадварын индексийг Дэлхийн эдийн засгийн форумгаас тооцож, уг судалгааныхаа дэд бүлэгтээ санхүүгийн системийн өрсөлдөх чадварыг багтаан авч үздэг. Тиймээс банк, даатгал, хөрөнгийн зах зээлээр тухайн улсын санхүүгийн системийн өрсөлдөх чадвар нь тодорхойлогддог. 2020 онд Монголын банкны холбооноос банкны өрсөлдөх чадварыг тодорхойлох зорилгоор тус индексийг тооцон гаргав. Цаашид тус индексийг тогтмол хугацаанд тооцохоор төлөвлөж байна. Энэхүү судалгаа нь банкуудын хувьд, олон улсын түвшинд хаана явж байгаагаа мэдэх боломжийг олгох бол харилцагч, олон нийтэд банкны салбарын үйлчилгээ, хүртээмж ямар түвшинд байгааг харьцуулан харах боломжийг тус тус нээж өгч байгаа юм. Түүнчлэн эрх баригч, бодлого боловсруулагчдад банкны салбарын хөгжилд макро эдийн засаг, улс төрийн орчин хэрхэн нөлөөлж буйг харах боломжийг бүрдүүлж өгч буйгаараа давуу талууд их юм.

Банкны өрсөлдөх чадварын индексийг тооцохдоо банкны салбарын дотоод хүчин зүйл болох банкны үр ашиг, олон нийтэд хүртээмжтэй байдал, улс орны эдийн засгийг дэмжиж буй байдал зэргээр тодорхойлсон бол гадаад хүчин зүйлийг макро эдийн засаг, улс төрийн орчин, хүн амын хөгжил, техник технологийн дэвшил зэрэг үзүүлэлтүүдийг сонгон авсан.

Банкны өрсөлдөх чадварын индекс нь дотроо 8 багана индекс, 18 үзүүлэлтийг агуулж байна. Эдгээрт банкны салбарын үзүүлэлтүүд болох үр ашиг, эрсдэл, гүнзгийрэл, хүртээмжийн үзүүлэлтүүд хамрагдаж байгаа бол нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдэд макро эдийн засгийн эрсдэл, хүн амын хөгжлийн үзүүлэлтүүд,





түүнчлэн засгийн газрын тогтвортой байдлын үзүүлэлтүүд мөн мэдээллийн технологийн үзүүлэлтүүдийг дэд бүлэгт хамруулан тооцсон билээ.

Судалгааны түүврийг сонгохдоо дараах 3 нөхцөл байдлыг харгалзан авч үзсэн. Нэгдүгээрт, Монгол Улс нь байгалийн баялагтай, уул уурхайгаас хамаардаг орон тул тус онцлогийг шингээсэн 22 улстай, Хоёрдугаарт, Монгол Улс нь дунджаас доогуур орлоготой орон тул мөн л ижил түвшний орлоготой улсуудыг сонгосон. Түүнчлэн бүс нутгийн онцлогийг ч харуулах зорилгоор Зүүн Ази, Номхон далайн улсуудаас түүврээ сонгосон. Улмаар давхардсан байдлаар нийтдээ 39 улсыг судалгаандаа хамруулсан болно.


Үзүүлэлтүүдийн тоо мэдээллийн эх үүсвэрийг сонгохдоо Дэлхийн банк, Олон улсын валютын сан, улс орнуудын Төв банкууд, олон улсын санхүүгийн байгууллагуудын дата баазыг ашиглан тоон мэдээллийг шинжлэн боловсруулав.

Бид индексийг тооцохдоо Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) нийлмэл хувьсагч боловсруулах аргачлалыг ашиглан боловсруулсан нь индексийн шат дараа болон шалгуурууд нь олон улсад нийцтэй, бодит индекс боловсруулахад ихээхэн тус нэмэр болж, олон улсын үзүүлэлтүүдийг харьцуулахад шаардагдах тоон өгөгдлийн дутмаг байдлыг хамгийн үнэнд ойр байхуйцаар үнэлэхэд шаардагдах онолын хөтөч болсон юм. Түүнчлэн, индексийг цаашид боловсруулахад нэгдсэн шатлалын дагуу тооцох боломжийг бүрдүүлж буйгаараа давуу талтай юм.



БАНКНЫ ОРЧИН

-  Багана 1
БАНКНЫ ҮР АШИГТ БАЙДАЛ
-  Багана 2
БАНКНЫ ЭРСДЭЛИЙН ТҮВШИН
-  Багана 3
БАНКНЫ САЛБАРЫН ГҮНЗГИЙРЭЛ
-  Багана 4
БАНКНЫ САЛБАРЫН ЗУУЧЛАЛ

ХҮНИЙ ХӨГЖИЛ

-  Багана 5
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИН

-  Багана 6
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН
-  Багана 7
УЛС ТӨРИЙН ОРЧИН

ДИЖИТАЛ ХӨГЖИЛ

-  Багана 8
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

4. БҮС НУТГИЙН ШИНЖИЛГЭЭ

Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг дахь орнуудын банкны өрсөлдөх чадварын индексийн зөрүү бага байна. Сонгогдсон 39 орнуудыг бүс нутгаар нь харьцуулав. Сахарын Өмнөд Африк болон Ойрх Дорнодын бүс нутгийн хувьд, индексийн зөрүү нэлээд өндөр байна. Харин Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг болон Хойд болон Өмнөд Америкийн бүс нутаг дахь өрсөлдөх чадварын индексийн зөрүү харьцангуй бага байна.

Өөрөөр хэлбэл, индексийн зөрүү өндөр байгаа нь тус улсуудад банкны нөхцөл байдал, макро эдийн засаг, улс төрийн орчин хоорондоо өндөр ялгаатай байгааг илтгэж байна.

Бүс нутгаарх банкны өрсөлдөх чадварын индексийн дундаж голч. Бүс нутгийн дунджийг харвал, Хойд болон Өмнөд Америк, Европ болон Австралийн бүс нутаг дахь банкны өрсөлдөх чадварын индекс нь хамгийн өндөр байна. Харин индексийн дунджаар хамгийн бага нь Төв ба Өмнөд Азийн бүс нутгийн орнууд байна.

Банкны өрсөлдөх чадварын индекс




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

5. УЛС ОРНУУДЫН ОРЛОГЫН ТҮВШНЭЭР ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Банкны өрсөлдөх чадварын индексийн зөрүү орлого буурах тусам нэмэгдэж байна. Бага орлоготой болон дунджаас доогуур орлоготой орнуудын дунд индексийн зөрүү нэлээд өндөр байна. Харин орлогын түвшин дээшлэх тусам индексийн зөрүү багасаж байна. Энэ нь дундаж болон дунджаас дээгүүр орлоготой орнуудын макроэдийн засгийн орчин, улстөрийн орчин харьцангуй тогтвортой байдагтай холбоотой. Түүнчлэн банкны

өрсөлдөх чадварын индексээс макро орчны нөлөөллийг хасаж тооцоход бага болон дунджаас доогуур орлоготой орнууд дахь индексийн зөрүү улам нэмэгдэж байсан бол өндөр орлоготой улсуудын индексийн зөрүү хадгалагдаж байв. Энэ нь дунджаас доогуур орлоготой орнуудын макро эдийн засгийн байдал тогтворгүй байгааг давхар илтгэж байна.

Банкны өрсөлдөх чадварын индекс



* 2016 оноос хойш төрийн оролцоотой банкуудаа чөлөөлж, банкны салбарт реформ хийж байгаа улс


Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

6. МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР ХААНА ЯВНА ВЭ?

Банкны өрсөлдөх чадварын индексээр Монгол Улс 39 улсаас 26-р байранд бичигдсэн байна. Ингэхдээ бүс нутаг, уул уурхайн хамаарал бүхий орон, орлогын ижил түвшний орнуудтай харьцуулан авч үзсэн. Ялангуяа бүс нутаг болон орлогын түвшин ижил орнуудтай харьцуулахад манай улс дээгүүр бичигдэж байна. Харин байгалийн баялагтай орнуудтай харьцуулахад 22 улсаас 15-р байранд

бичигдэж байна. Тэгвэл дараагийн харах ёстой зүйл бол манай улсын макро орчны тогтворгүй байдал нь банкны өрсөлдөх чадварыг хойш татаж байна уу? гэх асуудал. Макро орчны хүчин зүйлийг хасаж тооцсон(инфляц, гадаад өр) индексээр Монгол Улс нь 7 байр урагшилсан байна. Өөрөөр хэлбэл, 39 улсаас 15-р байранд бичигдэж байна.

Банкны өрсөлдөх чадварын индекс /Монгол Улсын эзэлсэн байр/



БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙГ ХЭРХЭН УНШИХ ВЭ?

1


Товч тайлбар хэсгээс тухайн индекс үзүүлэлтийг яагаад сонгосон, Монгол Улс хэддүгээр байр эзэлсэн зэрэг тайлбар мэдээллүүд байна.

2

Банкны өрсөлдөх чадварын индексийг улс орнуудаар жагсаасан. Түүнээс гадна нэгдсэн индекст багтсан дэд индексүүдээр сонгогдсон улсуудаар байр эзлүүлсэн.

3

Тус индекст тооцсон нэгж үзүүлэлтээр Монгол Улс хэддүгээр байранд орж байгааг харуулсан. Түүнчлэн тухайн үзүүлэлтээр хамгийн сайн оноо авсан улсуудыг харж болно.




7. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКСИЙН БҮРЭЛДЭХҮҮН

МОНГОЛ УЛС
26 / 39

БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС

Банкны өрсөлдөх чадварын ерөнхий индексээр Монгол Улс 26-р байранд жагсаж байна. Тус улсуудыг түүвэрлэн сонгохдоо бүс нутаг, орлогын түвшин, уул уурхайгаас хамааралтай байдал зэргээр нь авч үзсэн болно. Байгалийн баялгаас хамааралтай Саудын Арабаас гадна Канад, Австрали зэрэг хөгжингүй орнууд, түүнчлэн Өмнөд

Америкийн хөгжиж буй орнууд болох Колумб, Перу гэх улсууд нь индексийн эхний байруудыг эзэлж байна. Харин банкны өрсөлдөх чадвар харьцангуй бага байгаа улсууд нь макро эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдлаас ихээхэн хамаарч байна.




0-25 26-50 51-75 76-100

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ХАСАЖ ТООЦСОН ИНДЕКС

Банкны өрсөлдөх чадварын индексийг Монгол Улсын түвшинд түүврээр сонгогдсон орнуудтай харьцуулахад доогуур байгаа нь банкны салбарын үзүүлэлтээс шалтгаалж байна уу? эсвэл макро эдийн засаг болон

улс төрийн орчноос хамаарч байна уу? гэдгийг ялгаж харах нь зүйтэй. Тиймээс индексээс макро эрсдлийн үзүүлэлтийг ялган авч үзсэн. Үр дүнд нь макро орчныг ялгасан индексээр Монгол Улс 15-р байранд жагссан.



УЛСУУДЫН ГАЗАР НУТГИЙН
БАЙРШЛААР ХАРУУЛСАН АНГИЛАЛ

Түүвэрт сонгогдсон улс орнуудын индексийг бүс нутгаар нь авч үзье. Монгол Улс бүс нутгийнхаа түвшинд түүвэрлэгдсэн 5 орноос 2 дугаар байранд жагсаж байна. Харин макро орчны нөлөөллийг хассан индексээр 5 улсаас 1-т жагсаж байна.

Ерөнхий индексийн медианаараа Хойд болон Өмнөд Америкийн орнууд хамгийн өндөр оноотой байгаа ба Төв ба Өмнөд Азийн улсууд хамгийн бага медиантай байгаа нь банкны өрсөлдөх чадварын ялгаа нь улс орны тогтвортой байдал, геополитикийн хүчин зүйлсийн нөлөө их байгааг харуулж байна.

ЕВРОП БОЛОН АВСТРАЛИ			ХОЙД БОЛОН ӨМНӨД АМЕРИК			ОЙРХ ДОРНОД БА ХОЙД АФРИК		
БАЙР	УЛС	ОНОО	БАЙР	УЛС	ОНОО	БАЙР	УЛС	ОНОО
2	Австрали	68.6	3	Перу	68.4	1	Саудын Араб	73.3
10	ОХУ	65.1	4	Колумб	67.8	5	АНЭУ	67.6
17	Унгар	62.9	8	Бразил	66.6	6	Катар	67.4
35	Украйн	47.4	7	БНДУ	66.6	12	Армен	64.4
			9	Бразил	66.3	15	Турк	63.6
			14	Чили	63.9	19	Марокко	61.8
			18	Боливи	62.3	38	Судан	45.4
			22	Мексик	59.3			
Медиан оноо		64.0	Медиан оноо		66.4	Медиан оноо		64.4

ЗҮҮН АЗИ БА НОМХОН ДАЛАЙ			ТӨВ БА ӨМНӨД АЗИ			САХАРЫН ӨМНӨД АФРИК		
БАЙР	УЛС	ОНОО	БАЙР	УЛС	ОНОО	БАЙР	УЛС	ОНОО
13	Индонези	64.1	16	Узбекистан	63.3	11	Ботсвана	64.9
26	Монгол	57.4	30	Киргизстан	55.7	20	Өмнөд Африк	60.3
25	Вьетнам	57.4	31	Казахстан	54.6	21	Гана	59.4
28	Хятад	57.1	32	Тажикистан	54.2	23	Намиби	58.9
29	Филиппин	56.6	34	Энэтхэг	49.1	24	Зимбабве	57.9
			37	Пакистан	46.1	27	Мадагаскар	57.1
						33	Сенегал	50.7
						36	Камерун	46.4
						39	Ардчилсан Конго улс	36.4
Медиан оноо		57.4	Медиан оноо		54.4	Медиан оноо		57.9

■ 0-25 ■ 26-50 ■ 51-75 ■ 76-100

БҮС НУТГИЙН ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛАХАД ГАДААД ӨРИЙН ДАРАМТ ӨНДӨР БАЙНА

Зүүн Ази, Номхон Далайн орнуудтай харьцуулан эдийн засаг, хүний хөгжлийн голлох үзүүлэлтийг авч үзэв. Монгол Улс бүс нутгийн орнуудтай харьцуулахад, хүний хөгжлийн индексээр сайн байгаа хэдий ч эдийн засгийн хэмжээгээрээ бага, инфляцийн түвшин өндөр, гадаад


өрийн дарамт ихтэй, ажилгүйдэл өндөр байна. Сүүлийн 30 жил томоохон мега төслүүд хэрэгжсэн нь Камбож, Филиппин, Вьетнамтай харьцуулахад нэг хүнд ногдох ДНБ-ийг хурдтай өсөхөд хүргэжээ.

Улс орнуудын хөгжлийн голлох үзүүлэлт /2019 оны байдлаар/

	ХЯТАД	ФИЛИППИН	МОНГОЛ	ВЬЕТНАМ	КАМБОЖ
Хүн ам, сая	1,397.7	108.1	3.2	96.5	16.5
Дундаж наслалт	77	71	70	75	70
ХХИ байр	85	106	92	118	146
Хүний хөгжлийн индекс	0.76	0.71	0.74	0.69	0.58
Ажилгүйдэл	5.2	5.1	10.0	2.0	0.7
ДНБ, тэрбум \$	14,342.9	376.8	13.9	261.9	27.1
1 хүнд ногдох ДНБ, \$	8,254.3	3,337.7	4,350.2	2,082.2	1,269.0
Инфляц	2.9	2.5	7.3	2.8	2.0
Урсгал тэнцэл/ДНБ	1.0	-0.1	-15.6	5.0	-15.8
Засгийн газрын өр/ДНБ	52.6	37.0	64.8	43.4	28.6

Эх сурвалж: Дэлхийн банк

Нэг хүнд ногдох ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр



Эх сурвалж: Дэлхийн банк

УЛСУУДЫН ОРЛОГЫН ТҮВШНЭЭР АНГИЛСАН БАЙДАЛ

Түүвэрт сонгогдсон улс орнуудын индексийг орлогын түвшнээр нь авч үзье. Монгол Улс дунджаас доогуур түвшинд түүвэрлэгдсэн 15 орноос 6-р байранд жагсаж байна. Харин макро хүчин зүйлсийн орчны нөлөөллийг хассан индексээр 15 улсаас 2-т жагсаж байна.

Ерөнхий индексийн медианаараа өндөр орлоготой орнууд хамгийн өндөр оноотой байгаа ба бага орлоготой улсууд хамгийн бага медиантай байна. Уул уурхайн орнуудын нөөцийн зохистой хуваарилалт, засгийн газрын чадавхиас шалтгаалсан эдийн засгийн хүчин зүйлс нь банкны секторын хөгжилд ихээхэн нөлөөлж байгаа нь ажиглагдаж байна.

ӨНДӨР ОРЛОГОТой ОРНУУД			БАГА ОРЛОГОТой ОРНУУД		
БАЙР	УЛС	ОНОО	БАЙР	УЛС	ОНОО
1	Саудын Араб	73.3	27	Мадагаскар	57.1
2	Австрали	68.6	32	Тажикистан	54.2
4	Канад	67.8	39	Ардчилсан Конго улс	36.4
5	АНЭУ	67.6			
6	Катар	67.4			
14	Чили	63.9			
17	Унгар	62.9			
Медиан оноо		67.6	Медиан оноо		54.2

ДУНДЖААС ДООГУУР ОРЛОГОТой ОРНУУД			ДУНДЖААС ДЭЭШ ОРЛОГОТой ОРНУУД		
БАЙР	УЛС	ОНОО	БАЙР	УЛС	ОНОО
16	Узбекистан	63.3	3	Колумб	68.4
18	Боливи	62.3	8	Перу	66.6
19	Марокко	61.8	7	БНДУ	66.6
21	Гана	59.4	9	Бразил	66.3
24	Зимбабве	57.9	10	ОХУ	65.1
26	Монгол	57.4	11	Ботсвана	64.9
25	Вьетнам	57.4	12	Армен	64.4
29	Филиппин	56.6	13	Индонези	64.1
30	Киргизстан	55.7	15	Турк	63.6
33	Сенегал	50.7	20	Өмнөд Африк	60.3
34	Энэтхэг	49.1	22	Мексик	59.3
35	Украин	47.4	23	Намиби	58.9
36	Камерун	46.4	28	Хятад	57.1
37	Пакистан	46.1	31	Казахстан	54.6
38	Судан	45.4			
Медиан оноо		56.6	Медиан оноо		64.3

■ 0-25 ■ 26-50 ■ 51-75 ■ 76-100

ОРЛОГЫН ТҮВШИН ИЖИЛ ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛАХАД УРСГАЛ ТЭНЦЛИЙН АЛДАГДАЛ ӨНДӨР БАЙНА

Дэлхийн банкны ангиллаар дунджаас доогуур орлоготой орнуудын эдийн засаг, хүний хөгжлийн голлох үзүүлэлтийг авч үзэв. Монгол Улсын хувьд, хүний хөгжлийн индекс болон нэг хүнд ногдох ДНБ-ээр эдгээр улсуудаас дээгүүр


бичигдэж байна. Хэдий тийм боловч, макро эдийн засгийн нөхцөл байдал тогтвортой бус, өрийн дарамт өндөр байна. Тухайлбал, урсгал тэнцлийн алдагдал болон Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувиас харагдана.

Улс орнуудын хөгжлийн голлох үзүүлэлт /2019 оны байдлаар/

	УЗБЕКИСТАН	ФИЛИППИН	МОНГОЛ	КИРГИЗСТАН	КАМБОЖ
Хүн ам, сая	33.6	108.1	3.2	6.5	16.5
Дундаж наслалт	72	71	70	71	70
ХХИ байр	108	106	92	122	146
Хүний хөгжлийн индекс	0.71	0.71	0.74	0.67	0.58
Ажилгүйдэл	5.9	5.1	10.0	6.6	0.7
ДНБ, тэрбум ам.доллар	57.9	376.8	13.9	8.5	27.1
1 хүнд ногдох ДНБ, ам.доллар	2,459.0	3,337.7	4,350.2	1,116.4	1,269.0
Инфляц	14.5	2.5	7.3	1.1	2.0
Урсгал тэнцэл/ДНБ	-5.6	-0.1	-15.6	-5.6	-15.8
Засгийн газрын өр/ДНБ	29.3	37.0	64.8	54.1	28.6

Эх сурвалж: Дэлхийн банк

Нэг хүнд ногдох ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр




Эх сурвалж: Дэлхийн банк

УУЛ УУРХАЙН ХАМААРАЛ БҮХИЙ ОРНУУДЫН АНГИЛАЛ

Уул уурхай, металлын олон улсын зөвлөл (ICMM) нь эдийн засаг нь уул уурхайн орлогоос онцгой хамааралтай улс орны жагсаалтыг тэдний ДНБ-д эзлэх уул уурхайн үйлдвэрлэл, экспортод эзлэх хувь, уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтөөр нь тооцон гаргадаг

билээ. Эдгээр улсаас индексийн тооцооллод хамрагдсан 22 улс орныг жагсаахад Монгол Улс 15-р байранд орж байна. Харин макро орчны нөлөөллийг хассан индексээр 22 улсаас 10-т жагсаж байна.



0-25 26-50 51-75 76-100

УУЛ УУРХАЙН ХАМААРЛААС ГАРНА ГЭДЭГ АМАРГҮЙ


Монгол Улс нь тус улсуудаас эдийн засгийн үзүүлэлтээр орлого доогуур, инфляц нь өндөр талдаа, урсгал тэнцлийн алдагдал өндөр, гадаад өрийн дарамттай, газарзүйн байршил сул талтай болох нь харагдаж байна. Хэдийгээр эдийн засгийн өсөлт өндөр байгаа хэдий ч

савлагаа ихтэй, тогтворгүй байна. Байгалийн баялгаас хамаарал бүхий эдгээр улсууд нь эдийн засаг дахь уул уурхайн нөлөөг багасгах зорилгоор 1960 оноос хойш төрөл бүрийн бодлого, хөтөлбөр явуулж ирсэн ч өнөөг хүртэл тодорхой амжилтад хүрээгүй байна.


Уул уурхайгаас хамаарал бүхий орнуудын голлох үзүүлэлт /2019 оны байдлаар/

	ЧИЛИ	БОТСВАНА	МОНГОЛ	КАЗАХСТАН
Хүн ам, сая	18.7	2.2	3.2	18.2
Дундаж наслалт	79.7	67.6	70	70.0
ХХИ байр	44	102	92	60
Хүний хөгжлийн индекс	0.84	0.71	0.74	0.80
ДНБ, тэрбум ам.доллар	298.2	18.6	13.9	170.0
1 хүнд ногдох ДНБ, ам.доллар	15,130	8,031	4,350.2	11,166
Инфляц	2.3	2.8	7.3	5.2
Урсгал тэнцэл/ДНБ	-3.8	-7.6	-15.6	-3.6
Гадаад өр/ДНБ	27.9	15.1	64.8	19.9

Нэг хүнд ногдох ДНБ /зэрэгцүүлэх үнээр/



Эдийн засгийн өсөлт



Экспортын бүтэц


	ЭКСПОРТ НЭГ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭС ХАМААРЛАЙ ЭСЭХ	ГОЛЛОХ ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН	ТҮҮХИЙ ЭДЭЭС БУСАД ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН
Монгол	Тийм	Зэс, нүүрс- 88 хувь	Мах, арьс шир, ноолуур
Чили	Тийм	Зэс – 40 хувь	Жимс, загас, дарс, модон эдлэл
Казахстан	Тийм	Газрын тос, нефть – 57 хувь	Улаан буудай
Ботсвана	Тийм	Алмаз – 90 хувь	Давс, махан бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн

Эх сурвалж: Дэлхийн банк

БАНКНЫ ҮР АШИГТ БАЙДЛЫН ИНДЕКС

Банкны үр ашигт байдлын индексээр Монгол Улс 39 улсаас 31-т жагсаж байна. Банкны үр ашигт байдлыг тодорхойлохдоо хүүгийн зөрүү, активын болон өөрийн хөрөнгийн өгөөж гэх үзүүлэлтээр авч үзсэн. Улсуудаар

харьцуулсан үзүүлэлтүүдийг Дэлхийн банк болон зайлшгүй тохиолдолд тухайн улсын төв банкны тоон мэдээн дээр үндэслэн гаргав.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР

ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС


Хүүгийн зөрүү	18	Бразил
Активын өгөөж	35	Гана
Өөрийн хөрөнгийн өгөөж	35	Гана

БАНКНЫ ЭРСДЛИЙН ИНДЕКС

МОНГОЛ УЛС
29 / 39

Банкны эрсдлийн индексээр Монгол Улс 39 орноос 29-р байранд жагссан байна. Тус дэд индексийг тооцохдоо хөрвөх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, чанаргүй

зээлийн харьцаа зэрэг үзүүлэлтийг авч үзсэн. 2017 оноос хойш Монгол Улс активын чанарын үнэлгээ хийлгэсэнтэй холбоотой чанаргүй зээл огцом өссөн билээ.




МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР		ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС	
Хөрвөх чадварын үзүүлэлт	3	Судан	
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	30	Узбекистан	
Чанаргүй зээлийн харьцаа	33	Канад	

БАНКНЫ ГҮНЗГИЙРЛИЙН ИНДЕКС

Банкны гүнзгийрэлтийн индексээр Монгол Улс 39 орноос 20-р байранд жагссан байна. Тухайн банкны салбараас хувийн байгууллагад хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байгаагаас гүнзгийрэлт их, бага байгаа

нь харагддаг. Монгол Улсын санхүүгийн салбарын 90 гаруй хувийг банкны салбар эзэлдэг учраас дотоод дахь хөрөнгө оруулалтыг дангаараа бий болгодог.



МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР

ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС


Хувийн секторын зээлийн
ДНБ-д эзлэх хувь

20

Канад

БАНКНЫ САЛБАРЫН ЗУУЧЛАЛ НЭМЭГДЭЖ БАЙНА

Банкны салбарын зуучлал хэр түвшинд байгааг банкны актив, мөнгөний нийлүүлэлт, зээл гэх мэт үзүүлэлтийн ДНБ-д эзлэх хувиар тодорхойлдог. Банкны салбарын актив ДНБ-д эзлэх хувь 2000 онд 39 хувь байсан бол 2019 онд 97 хувьд хүрч нэмэгджээ.




Эх сурвалж: Монголбанк

БАНКНЫ ХҮРТЭЭМЖИЙН ИНДЕКС

Банкны хүртээмжийн индексээр Монгол Улс 39 орноос 1-р байранд жагссан байна. Газарзүйн хувьд өргөн тархсан байдал, бага хүн амтай улс хэдий ч 100 мянган

хүн амд ногдох банкны салбарын тоо, АТМ-н тоо бусад улс орнуудтай харьцуулахад банкны үйлчилгээний хүртээмж их байгааг илтгэж байна.



	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
100 мянган хүнд амд эзлэх банкны салбарын тоо	1	Монгол
100 мянган хүн ам тутамд эзлэх АТМ төхөөрөмжийн тоо	9	Колумб

БАНКНЫ САЛБАРЫН ХҮРТЭЭМЖ

Тухайн улсын харилцагчдад банкны үйлчилгээ хэр хүртээмжтэй, хүрэлцээтэй байгааг АТМ-н тоо, салбарын тоо, түүнчлэн зээл, хадгаламжийн дансны тоо гэх мэт олон үзүүлэлтээр тооцдог.
/2019 оны байдлаар/



2 ХҮН ТУТМЫН
1 НЬ МОБАЙЛ БАНКТАЙ




3 ХҮН ТУТМЫН
2 НЬ ИНТЕРНЭТ БАНКТАЙ




3 ХҮН ТУТМЫН
1 НЬ ЗЭЭЛТЭЙ



1 ХАДГАЛАМЖИЙН ДАНС
2 ХАРИЛЦАХ ДАНС



■ Салбарын тоо




■ ПОС машины тоо ■ АТМ машины тоо

Эх сурвалж: Монголбанк

МАКРО ЭРСДЛИЙН ИНДЕКС

Макро эдийн засгийн эрсдлийн индексээр Монгол Улс 39 орноос 39-р байранд жагссан байна. Гадаад эдийн засгаас хүчтэй хамаардаг, жижиг нээлттэй эдийн засгийн хувьд инфляцийн түвшин нь тогтворгүй байдаг нь нөлөөлсөн.

Түүнчлэн 2014 оноос хөгжиж буй орнуудын гадаад өрийн хэмжээ эрс нэмэгдсэн. Манай улсын хувьд гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хамгийн өндөр буюу өрийн дарамт ихтэй улсуудын тоонд орж байна.



	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Инфляцийн түвшин	26	Катар
Улсын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь	39	Ботсвана

ИРЭХ 3 ЖИЛД ГАДААД ӨРИЙН ДАРАМТ ӨНДӨР БАЙХААР БАЙНА


Цар тахлын нөхцөл байдалд 10-р сарын байдлаар төсвийн алдагдал 2 их наяд төгрөг давсан. Төсвийн зарлагын 39 хувь нь халамжид зарцуулагдаж байна. 2021 оны хувьд ч энэ дүр зураг хэвээр үргэлжлэх учраас 21, 22 оны төсөв өндөр алдагдалд хүрэхээр байна. Мөн ийм хүнд нөхцөлд

төсвийн орлогын 20, 30 хувьтай тэнцэхүйц гадаад бондын төлбөрүүд хүлээгдэж байна. 2011 онд Засгийн газрын өр ДНБ-ийн 20 хувьтай тэнцэж байсан бол 2020 онд 63 хувийг эзэлж байна. Ердөө сүүлийн 8 жилд өрийн хэмжээ 9 дахин өсжээ.

Бондын эргэн төлөлтийн хуваарь /сая ам.доллар/

БОНДУУДЫН НЭР	2019	2020	2021	2022	2023	2024	НИЙТ ДҮН
Үндсэн төлбөр			500	1,000	1,300	600	3,400
Чингис				1,000			1,000
Гэрэгэ					800		800
Хуралдай						600	600
Мазаалай			500				500
Самурай					500		500
Хүүгийн төлбөр	240	240	213	186	112	26	1,017

Засгийн газрын гадаад өр/ДНБ




Эх сурвалж: Монголбанк, YCX

ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКС

Хүн амын хөгжлийн түвшинг харуулах индексээр Монгол Улс 39 орноос 20-р байранд жагссан байна. Тухайн орны хүн амын хөгжлийн индекс нь дундаж наслалт, боловсролын түвшин болон амьжиргааны түвшинг

багтаан тооцдог. Түүнчлэн эдийн засгийн хөгжил, иргэдийн худалдан авах чадвар, хуримтлал үүсгэх боломж зэргийг нэг хүнд ногдох ДНБ-ээр хэмждэг.




	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Нэг хүнд ногдох ДНБ	21	Катар
Хүний хөгжлийн индекс	19	Австрали

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКСЭЭР ДЭЛХИЙН ДУНДЖААС ДЭЭГҮҮР БАЙНА

Дэлхий нийтээрээ хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас гадна хүний хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Хөгжлийн үндсэн зорилго нь хүнийг эрүүл саруул байх, урт удаан наслах, бүтээлчээр ажиллаж амьдрах таатай орчин, нөхцөлийг хүмүүст бүрдүүлэхэд чиглэж байна. Манай улсын хувьд хүний хөгжлийн индексээр дэлхийн

дундажтай харьцуулахад дээгүүр байгаа юм. Монгол Улсын хүн амын дундаж наслалт 2011-2019 онд 2.1 жилээр, сургуульд суралцах хугацаа 5.3 жилээр, сургуульд суралцахаар хүлээгдэж буй хугацаа 0.2 жилээр, нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 62.4 хувиар нэмэгдсэн байна.

Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индексүүд




Эх сурвалж: Монголбанк, ҮСХ

УЛС ТӨРИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ИНДЕКС

Улс төрийн тогтвортой байдлын индексээр Монгол Улс 39 орноос 21-р байранд жагссан байна. Улс төрийн зүгээс бизнес хийх таатай орчинг бүрдүүлж буй эсэх, түүнчлэн бизнесийн гэрээ, хэлцэлтэй холбоотой авлигын асуудал аль түвшинд байдаг эсэх, улс төрийн сонгуультай холбоотойгоор Засгийн газар нь ойр ойрхон солигддог

эсэх зэрэг үзүүлэлтээр хэмжсэн. Монгол Улсын хувьд, улс төрийн тогтвортой байдал 2017 оноос нэг нам засаг барьж буйтай холбоотой харьцангуй тогтвортой байна. Хэдий тийм боловч бизнесийн таатай орчин бүрдээгүй, авлига ихтэй хэвээр байна.



	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Бизнесийн таатай орчны индекс	21	Арабын Нэгдсэн Эмират Улс
Авлигын индекс	22	Австрали
Улс төрийн тогтвортой байдлын индекс	7	Австрали


МОНГОЛ УЛСАД УЛС ТӨРИЙН ОРЧИН ТОГТВОРТОЙ БАЙГАА Ч АВЛИГА, БИЗНЕС ХИЙХ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР СҮҮЛ МУШГИСААР БАЙНА

Цар тахал гарч, дэлхийн бүхий л улс орнуудад эдийн засаг дахь улс төрийн оролцоо нэмэгдэж байна. Тус байдлыг далимдуулан олон эрх баригч нам хууль, эрхзүйн өөрчлөлтүүдийг шинээр баталж байна. Ялангуяа цар тахлыг хяналтандаа авч чадсан Засгийн газруудын хувьд улиран сонгогдох боломжийг 2020 он ихээр олгов.

Авлигын индексээр дэлхийн 179 улсаас Монгол Улс 112-р байранд жагсаж байна. Түүнчлэн бүс нутаг болон дэлхийн дунджаас авлигын үзүүлэлтээр өндөр байна. Гэсэн хэдий ч урт хугацаандаа тус индекс буурах хандлагатай байна.

Бизнесийн таатай орчны индексээр дэлхийн 190 улсаас Монгол Улс 81-р байранд жагсаж байна. Монгол Улс гэрээний хэрэгжүүлэлт, мөрдөлт бага, ложистикийн асуудалтай, шүүхийн шийдвэр гаргалт удаан, зардал ихтэй зэрэг шалтгаан нь ийнхүү байр ухрахад нөлөөлсөн байна.

Авлигын индекс




Эх сурвалж: Дэлхийн банк

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ИНДЕКС

Мэдээлэл технологийн индексээр Монгол Улс 39 орноос 24-р байранд жагссан байна. Тус үзүүлэлтийг хүн амын дунд гар утас болон интернэт хэрэглэгчийн тоогоор

хэмжиж үзсэн. Хүн амын гар утас болон интернэт хэрэглээ нь банкны салбарын дижитал үйлчилгээг цаг хугацаа, орон зай харгалзахгүй ашиглах боломжийг бүрдүүлдэг.



	МОНГОЛ УЛСЫН ЭЗЭЛСЭН БАЙР	ХАМГИЙН САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ УЛС
Нийт хүн амд эзлэх гар утас эзэмшигчдийн тоо	2	Арабын Нэгдсэн Эмират Улс
Нийт хүн амд эзлэх интернэт хэрэглэгчдийн тоо	26	Катар


ЦАХИМ БАНКНЫ ТАЛААРХ ЗАЛУУ ҮЕИЙНХНИЙ ХАНДЛАГЫН СУДАЛГАА*

Энэхүү судалгаанд Z үеийнхний банкаар үйлчлүүлэх хандлагыг судалсан бөгөөд судалгааны үр дүнд залуучуудад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгохыг зорив.


- Судалгаанд 78 хүнийг хамруулсан бөгөөд залуучуудын цахим банкны хэрэглээ 95.2 хувьтай байв.
- Харилцагч банк шинэ цахим банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэхэд түүнийг ашиглах эрмэлзэл байдаг эсэхийг асуухад Z үеийн залуучууд тийм гэж хариулжээ. Харин энэ үзүүлэлт нь нас ахих тусам буурч байгаа юм.

- Ирээдүйд банкны салбар тэр чигтээ цахим хэлбэрт шилжих ёстой эсэхийг асуухад үр дүн харьцангуй эерэг байна. Энэ нь хүмүүст ирээдүйд шинэ технологийн дэвшил асар хурдацтай тархах хүлээлт байгаа ба тэд ийм өөрчлөлтийг нэн шаардлагатай гэж үзжээ.

Цахим банкны хэрэглээ /насны ангиллаар/



Цахим банкинд хандах хандлага /насны ангиллаар/



Энэхүү өгүүллийн хүрээнд банкны үйлчлүүлэгчдийг хамруулан цахимаар судалгаа авав. Судалгааг асуулгын аргаар авсан бөгөөд түүврийн хангалттай хэмжээг Словиний томьёо (Sugiyono, 2009)-оор оновчлов.

$$n = \frac{N}{N(d)^2 + 1} \quad (*)$$

Энд, n - Түүврийн хэмжээ.

N - Интернэт банк хэрэглэгчийн тоо.

d – 0.5%-ийн итгэх түвшин.

2020 оны 6 дугаар сарын байдлаар нийт интернэт банк хэрэглэгчдийн тоо 2,389,093 байгаа ба уг томьёоны дагуу судалгаанд шаардлагатай түүврийн хэмжээ 60.7 буюу 61 байна. Иймд судалгаанд 78 түүврийг хамруулсан нь эх олонлогийг ач холбогдолтой түвшинд тайлбарлаж чадахуйц хангалттай хэмжээ гэж үзэх үндэслэлтэй.

8. БАНКНЫ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС ТООЦОХ АРГА, АРГАЧЛАЛ

АГРЕГАТ ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ:

Банкны өрсөлдөх чадварын индексийг олон хэмжээт өгөгдлийг хураангуй индекс болгох аргачлалыг ашиглан (i) хувьсагчдыг нормалчлах; (ii) нормалчлагдсан хувьсагчдыг дэд индексүүд рүү нэгтгэх; (iii) дэд индексүүдийг эцсийн индекс болгон нэгтгэх байдлаар тооцоолсон. Банкны

өрсөлдөх чадварын индекст харилцан адилгүй, өөр төрлийн хэмжээс болон бүтэц бүхий индикаторуудыг нэгтгэн тооцоолохын тулд индикатор тус бүрийг "0-100"-ын хооронд оноолов. Индикатор тус бүрийг дараах томъёоны дагуу хувирган тооцоолов.

$$\text{Оноо}_{ic} = \underbrace{\left(\frac{\text{Бодит утга}_{ic} - \text{Мин утга}_i}{\text{Макс утга}_{ic} - \text{Мин утга}_i} \right)}_{\alpha} \times 100_i$$

Үүнд: Бодит утга нь "с" улсын "i" индикаторын цэвэр үзүүлэлт нь байх ба "Мин утга" нь тус үзүүлэлтийн хүлээн зөвшөөрөгдөх доод хэмжээг илэрхийлнэ. Мөн "Макс утга" нь тус үзүүлэлтийн байж болох дээд хэмжээг илэрхийлж буй болно. Индикатор тус бүрээс хамааран Макс утга нь тухайн үзүүлэлтийн бодлогын зорилтот дүн, боломжит дээд хэмжээ эсхүл перцентилд суурилсан дээд хэмжигдэхүүнийг илэрхийлнэ (жишээ нь дээд 90-95 дахь перцентилээс дээш гүйцэтгэл). Бодит утга нь "Мин утга" –аас бага байгаа тохиолдолд оноо нь 0 байх ба хэрвээ Бодит утга нь Макс утгаас өндөр байвал оноо нь 100 байхаар тооцооллыг хийсэн. Хэрэв тухайн индикатор урвуу индикатор байх тохиолдолд (жишээ нь гадаад өрийн ДНБ-д эзлэх хэмжээ, чанаргүй зээлийн хэмжээ г.м.) дээрх үзүүлэлтийг 100-с хасаж тооцох ба ингэснээр үзүүлэлтүүдийг нэгтгэх боломжтой болно.

ДУТУУ ТООН ӨГӨГДЛИЙН ТООЦООЛОЛ:

1. Дутуу тоон өгөгдлийн тооцоолол буюу "Missing data"-г нөхөхөд хугацаан цуваан тоон мэдээлэл дээр шугаман регрессийн шинжилгээ ашиглан тооцов. Тухайлбал АТМ машины тоо хүртээмжийн үзүүлэлтийг тооцоход үл хамааран хувьсагчид Хүн амын тооны өсөлт, Нэг хүнд ноогдох ДНБ-ийг ашиглан тооцоолов.
2. Харин хугацаан цувааны регрессээр илэрхийлэхэд логикийн хувьд үл тайлбарлагдах үзүүлэлтүүдийг Бүс нутаг, эдийн засгийн ижил төсөөтэй орнуудын үзүүлэлтийг дундажлах аргаар (Peer mean) тооцсон болно. Тухайлбал, Хувийн секторт олгосон зээлийн хэмжээг ДНБ-д эзлэх хувийг бүс нутгийн харьяалал (ОУВС) болон орлогын түвшний ангиллын (Дэлхийн банк) хувьд ижил төсөөтэй орнуудын дунджаар илэрхийлэв.

Банкны салбарын өрсөлдөх чадварын индексийг боловсруулахдаа дараах процедурийн дагуу гүйцэтгэв.

Тус индексийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) нийлмэл хувьсагч боловсруулах гарын авлагын онол практикийн зөвлөмжийн дагуу боловсруулсан болно.

1. ОНОЛЫН ХҮРЭЭ

- Банкны өрсөлдөөний хүчин зүйлсийн ойлголтыг нэгтгэх
- Өрсөлдөх чадварт нөлөөлөх, өрсөлдөх чадварыг илэрхийлэх дэд бүлгүүд боловсруулах

2. ТООН ӨГӨГДӨЛ СОНГОЛТ

Шинжилгээ хийхэд тохиромжтой эсэх, хэмжигдэхүйц байдал, улсуудын бэлэн байдал, банкуудын өрсөлдөх чадварын хүчин зүйлийг илэрхийлэхэд тохиромжтой эсэх мөн хоорондын харилцан хамаарлуудыг ажиглаж үзүүлэлтүүдийг сонгох. Хувьсагчийн хүртээмж бага тохиолдолд прокси хувьсагч сонгох

3. ДУТУУ ТООН ӨГӨГДЛИЙГ (MISSING DATA) ТООЦООЛОХ

- Дутуу тоон өгөгдлийн тооцооллыг хийх
- Тооцооллын найдвартай байдлыг үнэлэх, тоон үзүүлэлт нөхсөнөөр нэгтгэсэн үзүүлэлтэд үзүүлэх нөлөө
- Тоон өгөгдөлд гажууд утга (outliers) байгаа эсэхийг тодорхойлох

4. ОЛОН ХУВЬСАГЧДЫН ШИНЖИЛГЭЭ

- 2 голлох хэмжээст үзүүлэлт болон улсаар нь харьяалагдах тоон өгөгдлийн бүтцийг шалгах, тухайлбал (тохирох олон хувьсагчдын арга аргачлал, кластер шинжилгээ)
- Статистикийн хувьд ижил төстэй улсуудыг тодорхойлох, үр дүнг тайлбарлах
- Статистикийн хувьд ижил төстэй дата сетүүдийг онолын түвшинд тодорхойлж өгөх

5. ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ НОРМАЛЧЛАХ

- Онолын хүрээ болон тоон өгөгдлийн шинж чанарт тохирох нормалчлалын аргачлалыг сонгох
- Тоон өгөгдөлд гажууд үзүүлэлт байгаа эсэхийг тодорхойлж, хүсээгүй хандлагыг илэрхийлэхгүй байхаар тооцооллыг засварлах,
- Шаардлагатай тохиолдолд хамрах хүрээний хувьд засварлалт хийх
- Шаардлагатай тохиолдолд хэт налалттай үзүүлэлтүүдийг засварлах

6. ЖИНЛЭХ, АГРЕГРАТЧИЛАХ

- Онолын хүрээ болон тоон өгөгдлийн шинж чанарт тохирох жинлэх, агрегатчилах аргачлалыг сонгох
- Үзүүлэлтүүдийн хооронд корреляц байгаа эсэхийг тодорхойлох, засварлах шаардлагатай эсэхийг тодорхойлох
- Үзүүлэлтүүдийг орлуулах боломжийг тодорхойлох

7. ТОДОРХОЙ БУС БАЙДЛЫГ ШИНЖЛЭХ

Индексэд харгалзах бүхий л тодорхой бус байдлуудыг дурдах, үүнд харгалзах тодорхой бус байдлаар нь оноолох, зэрэглэл үүсгэх

8. ИНДЕКСИЙГ ШАЛГАХ

- Улс орны үзүүлэлтийг гаргаж харьцуулах, улмаар тухайн индексийн үр дүн нь ямар үзүүлэлтээр түлхүү илэрхийлэгдэж буйг тодорхойлох
- Хамаарал ба учир шалтгааныг тодорхойлох
- Хэт давамгайлж буй үзүүлэлтүүд байгаа эсэхийг тодорхойлж, засварлах, эсхүл тус үзүүлэлтийн ач холбогдлыг тайлбарлах

9. ХОЛБОГДОХ БУСАД ИНДЕКСҮҮДТЭЙ ХАМААРЛЫГ СУДЛАХ

- Боловсруулсан индексийн хамаарал бүхий бусад үзүүлэлтүүдтэй харьцуулах
- Үр дүнг тоон өгөгдөлд суурилсан өгүүлэмжээр илэрхийлэх

1-Р БҮЛЭГ:**Банкны үр ашигт байдлын индекс****1.1. Хүүний зөрүү**

(Зээлийн хүү) – (хадгаламжийн хүү) = (Хүүний зөрүү)

Банкны системийн зээлийн жигнэсэн дундаж хүү болон эх үүсвэрийн жигнэсэн дундаж хүүний зөрүү нь банкуудын ашигт ажиллагааг илэрхийлэх нэг үзүүлэлт юм.

1.2. Активын өгөөж

(Нийт орлого) / (Нийт Актив) = (Активын өгөөж)

Активын өгөөж нь цэвэр ашгийг нийт активт харьцуулсан харьцаа юм. Энэ нь нэгж активаас хэдэн хувийн өгөөж авч буйг илэрхийлж байгаа ашгийн үзүүлэлт юм. Активын өгөөж нь нийт активаа хэр хэмжээний үр ашигтайгаар удирдаж байгааг харуулдаг голлох үзүүлэлт бөгөөд банкны системд өргөн ашиглагддаг үзүүлэлт юм.

1.3. Өөрийн хөрөнгийн өгөөж

(Нийт орлого) / (Нийт өөрийн хөрөнгө) = (Өөрийн хөрөнгийн өгөөж)

Татварын дараах цэвэр ашгийг нийт өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцааг өөрийн хөрөнгийн өгөөж гэж нэрлэнэ. Энэ нь хувьцаа эзэмшигчдийн өгөөж жилд хэдэн хувиар өөрчлөгдсөнийг илэрхийлж буй үзүүлэлт юм.

2-Р БҮЛЭГ:**Банкны эрсдлийн индекс****2.1. Хөрвөх чадвартай активын нийт активт эзлэх хувь**

(Хөрвөх чадвартай активын нөөц) / (Нийт актив)

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь компанийн богино хугацааны үүрэг, мөнгөн гүйлгээг нөхөх чадварыг тодорхойлдог учраас банкны эрсдлийг тодорхойлоход оновчтой үзүүлэлт юм.

2.2. Нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ

(Нийт өөрийн хөрөнгө) / (Нийт Актив) = (Нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ)

Эрсдэлт үед банкны активыг санхүүжүүлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсэхийг тооцоолдог тус үзүүлэлт нь улс хоорондын харьцуулалт гаргахад тохиромжтой үзүүлэлт юм.

2.3. Чанаргүй зээлийн харьцаа

(Нийт чанаргүй зээлийн хэмжээ) / (Нийт зээлийн хэмжээ)*100% = (Чанаргүй зээлийн харьцаа)

Чанаргүй зээлийн харьцаа: Тус үзүүлэлт олон улсад банкны салбарын активын чанарыг харьцуулдаг цөөхөн үзүүлэлтүүдийн нэг билээ.

3-Р БҮЛЭГ:**Банкны гүнзгийрлийн индекс****3.1. Бизнесийн зээл болон ДНБ-ийн харьцаа**

(Дотоодын бизнесийн зээлийн хэмжээ) / (Дотоодын нийт бүтээгдэхүүн) = Бизнесийн зээл болон ДНБ-ийн харьцаа

Хувийн секторын зээлийн ДНБ-д эзлэх хувь: Энэ нь банкны салбарын санхүүгийн зах зээл дэх гүнзгийрэлтийг харуулдаг. Өөрөөр хэлбэл, тухайн санхүүгийн зах зээлээс хувийн байгууллагад хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байгаагаас гүнзгийрэлт их, бага байгаа нь харагддаг. Нийт хувийн байгууллагуудад олгосон зээлийн хэмжээг нийт дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулснаар бусад улс орнуудтай харьцуулах боломж бүрдэнэ.

4-Р БҮЛЭГ:**Банкны хүртээмжийн индекс****4.1. 100 мянган хүнд ногдох банкны салбарын тоо**

(Нийт банкны салбарын тоо) / (Нийт хүн амын тоо) * 100,000 = 100,000 хүнд ногдох банкны салбарын тоо

100 мянган хүн ам тутамд эзлэх банкны салбарын тоо: Энэ нь банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ хүн амд хүртээмжтэйгээр хүрч чадаж байгаа эсэхийг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг билээ.

4.2. 100 мянган хүнд ногдох АТМ машины тоо

(Нийт АТМ-ын тоо) / (Нийт хүн амын тоо) * 100,000 = 100,000 хүнд ногдох АТМ-ны тоо

100 мянган хүн ам тутамд эзлэх АТМ төхөөрөмжийн тоо: Энэхүү үзүүлэлт нь банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ хэр хүртээмжтэй байгааг илэрхийлдэг учраас банкны өрсөлдөөнийг тодорхойлох чухал үзүүлэлт болдог.

5-Р БҮЛЭГ:**Макро эрсдлийн индекс****5.1. Инфляц, хэрэглэгчийн үнээр (жилээр)**

(Өмнөх жилийн хэрэглээний үнийн индекс) / (тухайн жилийн хэрэглээний үнийн индекс) * 100 - 100 = (Инфляцийн түвшин)

Инфляцийн түвшин: Энэхүү индексд инфляцийн түвшний сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийг тооцож ашигласан. Инфляцийн түвшин нь улс бүрийн эдийн засгийн идэвхжил, мөн эрсдлийг тооцоход чухал үзүүлэлт юм.

5.2. Гадаад өр болон ДНБ-ийн харьцаа

(Нийт гадаад өр) / (ДНБ) = (Гадаад өр ДНБ-ний харьцаа)

Улсын нийт гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь: Банкны системийн өсөлт хөгжилд тухайн улсын гадаад эрсдэл олон талаараа шууд нөлөөтэй юм. Улсын нийт гадаад өрийн үзүүлэлтээр макро эдийн засгийн эрсдэл, гадаад хүчин зүйлийг илэрхийлэгч голлох үзүүлэлтийн нэг билээ.

6-Р БҮЛЭГ:

Хүн амын хөгжлийн индекс

6.1. Худалдан авах чадварын тэнцлээр нэг хүнд ногдох ДНБ

Дотоодын нийт бүтээгдэхүүний худалдан авах чадварын тэнцэл ашиглан ам.доллар луу шилжүүлэн тооцооллох

Нэг хүнд ногдох ДНБ нь тухайн орны ДНБ-ийг нийт хүн амд хувааж тооцоолдог. Тухайн орны эдийн засгийн хөгжил, иргэдийн худалдан авах чадвар, хуримтлал үүсгэх боломж зэрэг банкны салбарт нэн шаардлагатай үзүүлэлтүүдийг энэ индексээр тодорхойлох бүрэн боломжтой.

6.2. Хүний хөгжлийн индекс

Хүний хөгжлийн индексийг тухайн орны газар зүйн байршил, дундаж наслалт болон дотоодын нийт орлогод тулгуурлан тооцдог

Энэхүү үзүүлэлт нь тухайн орны хөгжил, эдийн засгийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох суурь болж өгдөг учир банкны салбарын хөгжилд шууд болон шууд бусаар хамааралтай үзүүлэлт юм.

7-Р БҮЛЭГ:

Улс төрийн тогтвортой байдлын индекс

7.1. Бизнесийн таатай орчны индекс

Бизнесийн таатай орчны индексийг тухайн орны хууль эрх зүйн орчны дагуу бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэхэд шаардагдах хоногийн тусламжтайгаар тооцно.

Бизнесийн таатай орчны индекс нь тухайн оронд бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай байдлыг эрх зүй, дэд бүтэц болон санхүүгийн секторын хөгжил, аюулгүй байдлын түвшинд судлаж тогтоодог. Энэхүү индексийн тусламжтайгаар тухайн орны бизнесийн орчны аюулгүй байдлыг тодорхойлохоос гадна бизнес эхлүүлэх, маргаан шийдвэрлэх эрх зүйн орчин болон эдийн засгийн бусад үйл ажиллагааны бүтээмжийг урьдчилан тодорхойлох боломжтой. Иймд, бизнесийн таатай орчны индекс нь тухайн оронд үйл ажиллагаа явуулах гэж буй бизнес эрхлэгч бүрийн зайлшгүй авч үзэх шаардлагатай үзүүлэлт юм.

7.2. Авлигын индекс

13 өөр төрлийн авлигын талаарх судалгаан дээр үндэслэн тогтоодог.

Авлигын индекс нь тус орны төрийн байгууллагуудын авлигад автсан байдлыг тухайн орны бизнес эрхлэгчид болон судалгааны байгууллагуудтай хамтран 13 төрлийн индикатор дээр үндэслэн тогтоодог. Авлигын индексийн тусламжтайгаар бизнес эрхлэгчид нь тухайн оронд үйл ажиллагаа явуулахад хэр хүндрэлтэй байх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллахад тулгарах авилга, хүнд суртлыг урьдчилан тодорхойлж өөрсдийн бизнесийн төлөвлөгөөнд энэхүү эрсдлийг тооцоолох боломжтой болох юм.

7.3. Улс төрийн тогтвортой байдлын индекс

Улс төрийн тогтвортой байдлын индексийг тухайн оронд жилдээ гарч буй үймээн самуун, бослого, төрийн эргэлтийн тоог бусад орны мэдээлэлтэй харьцуулж гаргадаг.

Улс төрийн тогтвортой байдлын индекс нь тухайн оронд хууль бус замаар засгийн газрыг огцруулах, төрийн эргэлт хийх, хүчирхийлэл болон цэргийн хүчээр засгийн эрхийг авах гэх мэт эрсдлүүдийг тодорхойлдог. Энэхүү индекс нь банк санхүүгийн салбарт их хэмжээний эрсдэл дагуулах боломжтой ба тухайн орны хууль эрх зүйн орчин, мөнгөний бодлогод шууд нөлөөлөлтэй байдаг тул дээрх индексийг тооцоололд ашиглах зайлшгүй шаардлагатай.

8-Р БҮЛЭГ:

Мэдээллийн технологийн индекс

8.1. Нийт хүн амд эзлэх интернет хэрэглэгчдийн тоо

(Нийт интернет хэрэглэгчдийн тоо) / (Нийт хүн амын тоо) = (Нийт хүн амд эзлэх интернет хэрэглэгчдийн тоо)

Хүн амын интернет хэрэглээ нь банкны салбарын дижитал үйлчилгээг газар харгалзалгүй ашиглах боломжийг бүрдүүлдэг. Тиймээс тус үзүүлэлт нь онлайн банкны үйлчилгээг авах боломжийг тооцоолоход чухал үзүүлэлт билээ.

8.2. 100 хүн тутамд дахь гар утас эзэмшигчдийн тоо

(Нийт гар утас эзэмшигчдийн тоо) / (Нийт хүн амын тоо) * 100 = (100 хүн тутамд дахь эзлэх гар утас эзэмшигчдийн тоо)

Хүн амын гар утасны хэрэглээ нь банкны салбарын мобайл банкны үйлчилгээг газар харгалзалгүй ашиглах боломжийг бүрдүүлдэг. Тиймээс тус үзүүлэлт нь зайнаас банкны үйлчилгээг авах боломжийг тооцоолоход чухал үзүүлэлт билээ.

9. ИЖИЛ ТӨСТЭЙ ОРНУУДЫН БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОНЦЛОГ

КИРГИЗСТАН УЛС

- Банкны салбарын гүнзгийрэлт нэлээд багатай. Тухайлбал, банкны зээл болон хадгаламж ДНБ-ний ердөө 24 хувьтай тус тус тэнцдэг.
- Тус улсад Нигери, Филиппин, Камбож гэх мэт ижил орлогын түвшинтэй улсуудтай харьцуулахад дижитал үйлчилгээ, финтек компаниудын хөгжил дөнгөж эхэлж байна.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Киргизстан улсын санхүүгийн салбар нь банкны систем давамгайлсан, Монгол Улстай ихээхэн төстэй. 2000 онд санхүүгийн секторын нийт хөрөнгө ДНБ-ний 10 хувь байсан бол 2011 онд 32 хувь, 2019 онд 46.7 хувьд хүрч тус тус өсжээ. Харин банкны салбарын актив дангаараа ДНБ-ний 35 хувьтай тэнцэж байна. Нийтдээ 24 банк (11 банкны 50-с дээш хувийг гадаад хөрөнгө оруулагчтай), 634 банк бус санхүүгийн байгууллага, 19 даатгалын компани, 9 хөрөнгө оруулалтын сантай. Хэдийгээр дундаж хүү 14.8 хувь байгаа ч томоохон банкны самбарын хүү 25-28 хувьтай байна.

	2010	2015	2019
Банкны актив/ДНБ	28%	42%	42%
Банкны зээл/ДНБ	15%	22%	24%
Банкны депозит/ДНБ	12%	21%	24%
Бодлогын хүү	5.5%	10%	4%
Зээлийн хүү	20.9%	18.8%	14.8%
Хадгаламжийн хүү	3.7%	4.8%	4.2%

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Чанаргүйдэл. 2019 онд банкуудын зээлийн багц дахь чанаргүй зээлийн эзлэх хувь 7.8 байна. Ихэнх зээл нь худалдаа, ХАА-н салбарт олгогддог бөгөөд худалдааны салбарын чанаргүйдэл өндөр байна.


Хөрвөх чадварын харьцаа. Киргизстаны Төв банкны тогтоолын дагуу арилжааны банкуудын хөрвөх чадварын харьцаа 45 хувь хэмээн тогтоосон. 2019 онд Киргизстаны банкны системийн хөрвөх чадварын харьцаа 66.9 хувийн үзүүлэлттэй байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ. Киргизстаны Төв банкны тогтоолын дагуу банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 12 хувь хэмээн тогтоосон бөгөөд 2019 онд банкны системийн энэхүү харьцаа нь 24 хувийн үзүүлэлттэй байна.


	2010	2015	2019
Хөрөнгийн хүрэлцээний харьцаа	30.5%(>12%)	22.4%(>12%)	24%(>12%)
Хөрвөх чадварын харьцаа	73%(>30%)	77.8%(>45%)	66.9%(>45%)




Активын өгөөж



Өөрийн хөрөнгийн өгөөж



Чанаргүй зээлийн харьцаа



УЗБЕКИСТАН УЛС

- Сүүлийн 20 жил банкны салбар нь төрийн өндөр оролцоотой байсан хэдий ч шинэ ерөнхийлөгч гарч ирснээр банкны салбарын реформ хийгдэж эхэлсэн.
- Банкны салбарын шинэчлэл хийгдсэнээр гадны хөрөнгө оруулагчид сонирхож эхэлсэн. Тухайлбал, Гүрж, Казахстангаас Узбекистанд банкны салбар байгуулах сонирхол өндөр байна.



БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Узбекистан улсын санхүүгийн систем нь банкны систем дээр тулгуурласан бөгөөд арилжааны банкууд гол үүрэг гүйцэтгэдэг. Узбекистанд 29 арилжааны банк үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнд төрийн өмчит 5-н банк, төрийн өмчийн оролцоотой 13 хувьцаат банк, гадаадын хөрөнгө оруулалттай 5 банк, хувийн хэвшлийн 6 банк багтдаг. Нийт активын тал хувийг төрийн өмчийн оролцоотой 3 банк бий болгодог. Тус улсад шинэ ерөнхийлөгч гарч ирснээр 2016 оноос хойш санхүүгийн зах зээлд шинэчлэл хийж эхэлсэн. Үүний үр дүнд санхүүгийн зуучлал эрс нэмэгдсэн байна. Төрийн оролцоот банкуудын өр төлбөрийн ердөө 30 орчим хувь иргэд, байгууллагаас татсан хадгаламж байдаг бол хувийн банкуудын өр төлбөрийн 73 хувь нь байна. Төрийн оролцоо ихтэй учраас тус салбарт ил тод байдал багатай.

	2010	2015	2019
Банкны актив/ДНБ	35%	41%	52%
Банкны зээл/ДНБ	20%	24%	41%
Банкны депозит/ДНБ	22%	22%	17%
Бодлогын хүү	14%	9%	16%
Зээлийн хүү	20.9%	13.9%	24.8%
Хадгаламжийн хүү	9.3%	13.5%	17.3%

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Чанаргүйдэл. Зээлийн чанаргүйдэл багатай байдаг нь өнгөрсөн жилүүдэд банкны салбар дахь төрийн оролцоо өндөр байсантай холбоотой. Ихэвчлэн төрийн хөрөнгө оруулалтын төслүүдэд зээл олгох замаар үйл ажиллагаагаа явуулдаг. Тиймээс активын 1.5 хувь нь чанаргүйтсэн зээл бүрдүүлж байна.

Хөрвөх чадварын харьцаа. Төв банкнаас тогтоосон банкны хөрвөх чадварын харьцааны доод хэмжээ нь 30% бөгөөд 2019 онд Узбекистан улсын банкуудын хөрвөх чадварын харьцаа 82 хувийн үзүүлэлттэй байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ. Узбекистан улсын банкны өөрийн хөрөнгийн харьцааг 13% гэж тогтоосон бөгөөд 2019 оны байдлаар банкны өөрийн хөрөнгийн харьцаа 15.6 хувийн үзүүлэлттэй байна.



НИГЕРИ УЛС

- Банкны салбарын зуучлал, хүртээмж багатай. Иргэд болон байгууллагын депозитын ДНБ-д харьцуулсан хувь сүүлийн 9 жилд өсөөгүй. Тиймээс тус улс нь банкны салбартаа реформ хийж байна.
- Дижитал банкыг сүүлийн жилүүдэд өргөн ашиглаж байна. Ялангуяа цар тахлын үед нийт гүйлгээний 87 хувь нь дижитал платформоор хийгдсэн байна.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Бүс нутгийн орнуудтай харьцуулахад банкны салбарын хүртээмж, гүнзгийрэлт багатай. Тусгай зөвшөөрөлтэй банкны тоо 2018 онд 27 байсан бол 2019 оны 12-р сарын сүүлчээр 29 болж өссөн. Тусгай зөвшөөрөлтэй банкуудад 22 арилжааны банк, 5 мерчант банк, 2 исламик банк багтдаг. Ихэнх улс орнууд банкны реформыг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд хийдэг бол Нигери улс нь тус реформыг санхүүгийн зуучлал нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг бий болгох, санхүүгийн тогтолцоонд итгэх итгэлийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү хийж байна.


	2010	2015	2019
Банкны актив/ДНБ	32%	30%	29%
Банкны зээл/ДНБ	20%	19%	16%
Банкны депозит/ДНБ	18%	18%	17%
Бодлогын хүү	6.3%	11%	13.5%
Зээлийн хүү	17.6%	16.8%	15%
Хадгаламжийн хүү	2.2%	3.6%	3.9%

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Чанаргүйдэл. Чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт Монгол Улстай ойролцоо түвшинд байдаг. 2010 оноос хойш энэхүү харьцаа үзүүлэлтэд төдийлөн өөрчлөлт ороогүй.

Хөрвөх чадварын харьцаа. Төв банкнаас тогтоосон банкны хөрвөх чадварын харьцааны доод хэмжээ нь 30% бөгөөд 2019 онд Нигери улсын банкуудын хөрвөх чадварын харьцаа 103.9 хувийн үзүүлэлттэй байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ. Нигери улсын банкны өөрийн хөрөнгийн харьцааг 10% хэмээн тогтоосон бөгөөд 2019 оны байдлаар банкны өөрийн хөрөнгийн харьцаа 15 хувийн үзүүлэлттэй байна.



ФИЛИППИН УЛС

- Хөгжиж буй орнуудтай харьцуулахад финтек дээр тулгуурласан бичил зээл хөгжсөн. Цар тахалтай холбоотой дижитал шилжилтийг хурдацтай хийж байна. Гэсэн хэдий ч иргэдийн 60 хувь нь интернэтэд холбогдоогүй.
- Бүс нутгийн орнуудтай харьцуулахад банкны салбарын зуучлал, хүртээмж бага боловч орлогын түвшин ижил орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр. Ялангуяа хүмүүсийн ахиу хадгалах хандлага өндөр байна.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Филиппин улсын санхүүгийн салбарын нийт хөрөнгийг ДНБ-тэй харьцуулсан харьцаа бүс нутгийн улсуудаас харьцангуй бага үзүүлэлттэй байдаг. Мөн тус улсын хувьд бүс нутгийн хамгийн эртний үнэт цаасны зах зээлтэйд тооцогддог ч санхүүгийн зуучлал нэлээд хоцрогдсон. Банкны секторын төвлөрөл харьцангуй бага. 2011 оноос хойш зээлийн ДНБ-д эзлэх хувь огцом өссөн байгаа нь үл хөдлөхийн зээл нэмэгдсэнтэй холбоотой.

	2010	2015	2019
Банкны актив/ДНБ	74%	87%	94%
Банкны зээл/ДНБ	35%	47%	56%
Банкны депозит/ДНБ	55%	75%	70%
Бодлогын хүү	4%	4%	4.5%
Зээлийн хүү	7.7%	5.6%	7.1%
Хадгаламжийн хүү	2.9%	1.5%	4%

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:


Чанаргүйдэл. Тус улсын зээлийн чанаргүйдэл харьцангуй бага. Түүнчлэн сүүлийн 9 жилд чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт 3.8 хувиас 2 хувь хүртэл буурсан. Зээлийн бүтэц дотроо хэрэглээний зээлийн чанаргүйдэл харьцангуй өндөр байна.

Хөрвөх чадварын харьцаа. Төв банкнаас тогтоосон банкны хөрвөх чадварын харьцааны доод хэмжээ нь 100% бөгөөд 2019 онд банкуудын хөрвөх чадварын харьцаа 169 хувийн үзүүлэлттэй байна.


Өөрийн хөрөнгийн хүрэлцээ. Филиппин улсын Төв банкны тогтоосноор банкны өөрийн хөрөнгийн харьцаа хамгийн багадаа 10 хувь байхаар заасан бөгөөд 2019 оны байдлаар тус улсын банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ 15.6 хувийн үзүүлэлттэй гарсан байна.

ДИЖИТАЛ ТӨЛБӨР ТООЦОО:


Филиппин улсын хувьд Ковид-19 цар тахлаас улбаалан дижитал төлбөр хурдацтай хөгжиж байгаа бөгөөд аливаа санхүүгийн гүйлгээ, шилжүүлгийг нүүр тулан хийх нь аюултай болсон учраас дижитал төлбөрийг хөгжүүлэхэд маш ихээр анхаарч байна. Цар тахал үүссэний дараачаар Филиппин улсын хувьд цахим шилжүүлэгт тохирсон PesoNet болон InstaPay-н хэрэглээ огцом өссөн.




Активын өгөөж



Өөрийн хөрөнгийн өгөөж



Чанаргүй зээлийн харьцаа



КАМБОЖ УЛС

- Тус улс нь орлогын түвшин ижил орнуудтай харьцуулахад банкны салбарын гүнзгийрэлт ихтэй. Тухайлбал, 2010 онд банкны зээл болон депозитын ДНБ-ний 20-30 хувийг эзэлж байсан бол 2019 онд 95-98 хувийг бүрдүүлж байна.
- Санхүүгийн зуучлал, хүртээмжийг нэмэгдүүлснээр ядуурлын түвшинг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Ядуурлын түвшин 2004 онд 43 хувь байсан бол 2014 онд 15 хувьд хүрчээ. Мөн үед банк, санхүүгийн үйлчилгээг хүн амын 10 гаруй хувь нь ашигладаг байсан бол 2014 онд 50 хувь хүртлээ өсжээ.

БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ОНЦЛОГ:

Камбож улсын санхүүгийн салбар нь чөлөөтэй боловч хөрөнгийн урсгалын хувьд хязгаарлалттай. Тус улсын банкууд бүгд хувийнх бөгөөд ихэнх нь гадаадын хөрөнгө оруулалттай. 2019 оны хувьд нийт 47 арилжааны банк, 15 төрөлжсөн банк, 6 төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс нийт хөрөнгийн 80 гаруй хувийг банк бүрдүүлж байна.


	2010	2015	2019
Банкны актив/ДНБ	63%	123%	137%
Банкны зээл/ДНБ	21%	58%	98%
Банкны депозит/ДНБ	32%	55%	95%
Зээлийн хүү	22%	16.2%	15%
Хадгаламжийн хүү	6.6%	6.6%	8.5%

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ:


Чанаргүйдэл. Тус улсын зээлийн чанаргүйдэл харьцангуй бага. Сүүлийн 10 жилд тус улсын чанаргүй зээлийн харьцаа 2-3 орчим хувьд байна.

Хөрвөх чадварын харьцаа. Арилжааны банкуудын дундаж хөрвөх чадварын харьцаа 2019 оны байдлаар 155.7 хувийн үзүүлэлттэй гарсан бөгөөд хөрвөх чадварын харьцааны жишиг үзүүлэлтийн 90 хувиас өндөр байна.


Өөрийн хөрөнгийн хүрэлцээ. Камбож улсын Төв банкны тогтоосноор банкны өөрийн хөрөнгийн харьцаа хамгийн багадаа 15 хувь байхаар заасан бөгөөд 2019 оны байдлаар тус улсын банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ 24.0 хувийн үзүүлэлттэй гарсан байна.




Активын өгөөж



Өөрийн хөрөнгийн өгөөж



Чанаргүй зээлийн харьцаа




10. МОНГОЛ УЛСЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ТОЙМЛОХ НЬ


Дэлхийн эдийн засгийн форумаас өрсөлдөх чадварын индексийг жил бүр тооцон гаргадаг. Энэхүү индекс нь эдийн засаг, нийгмийн орчин, хүний хөгжил, зах зээл, инновац гэсэн нийтдээ 4 бүлэг, 12 дэд бүлгээс бүрдэнэ. Дунджаар 140 орчим улсыг жил бүр хамруулж тооцдог. Сүүлийн 12 жил Монгол Улс өрсөлдөх чадварын индексээр

93-117-р байрны хооронд жагсаж байжээ. Орлогын түвшин ижил орнуудтай харьцуулахад доогуур бичигдэж байна. Ердөө Оюутолгой төсөл эхэлсэн, нүүрсний экспорт нэмэгдсэн 2010-2013 оны хооронд орлогын түвшин ижил орнуудаас дээгүүр бичигдэж байсан байна.

Өрсөлдөх чадварын индекс, эзлэх байраар



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум, ҮСХ




Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум, YCX

2019 ОНД Монгол Улс ӨРСӨЛДӨХ ЧАДВАРААРАА 141 ОРНООС 102-Т ЖАГСАЖ БАЙНА

Монгол Улсын өрсөлдөх чадварын индексийн бүтцээр нь авч үзвэл, индексийг доогуур гарахад хамгийн их нөлөөлж буй үзүүлэлт нь **макро эдийн засгийн тогтвортой байдал** байна. Тус үзүүлэлтээр Монгол Улс 120-р байранд жагсаж байна. Өөрөөр хэлбэл, Монгол

Улсын инфляц тогтворгүй байдаг, гадаад өрийн хэмжээ өндөр байгаа зэрэг нь макро эдийн засгийн тогтворгүй байдалд нөлөөлжээ. Түүнчлэн санхүүгийн системийн хувьд, 108-р байрыг эзэлж байгаа нь даатгал, хөрөнгийн зах зээл төдийлөн хөгжөөгүйтэй холбоотой байна.

Монгол Улсын өрсөлдөх чадвар



11. БАНКНЫ САЛБАРЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

БАНКНЫ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДАЛ

Монгол Улсад Үндэсний банк байгуулагдаж, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг гүйлгээнд гаргасан явдал нь илд, сэлэмгүйгээр хувьсгал хийн санхүүгийн зах зээлд тусгаар тогтнолыг зарласан чухал үйл явдал байв.

1921 - 1924

ҮНДЭСНИЙ БАНК БАЙГУУЛАГДАВ

1924.06.02-нд Монгол, Зөвлөлт Орос улсын хувь нийлүүлсэн хөрөнгөөр "Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк" байгуулагдсан.

1925.02.22-нд тогтоол гаргаж үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг гаргах эрх олгов. Тухайн үед 1, 2, 5, 10, 25, 50, 100-тын дэвсгэрт гүйлгээнд гаргасан.

1925 - 1954

ТӨГРӨГ ГҮЙЛГЭЭНД ОРОВ

Мөнгөний явдлыг шинэчлэн сайжруулах комисс 1925 онд байгуулагдсан.

1927 оноос бүх төлбөр, тооцоог төгрөгөөр хийх болсон.

1954 - 1990

"БНМАУ-ЫН БАНК" БОЛСОН

ЗХУ өөрийн хөрөнгөө шилжүүлснээр 1954.04.12-нд "БНМАУ-ын банк" болсон.

1990 онд Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм батлагдав.

1991 оноос хойш

2 ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦООНД ШИЛЖИВ

1991 онд банкны тухай хууль батлагдав

Мөнгөний бодлого хэрэгжүүлэх, эдийн засгийг мөнгөөр дамжуулан төрөөс зохицуулах

БАНКНЫ ДАМПУУРАЛ

Макро эдийн засгийн тогтворгүй байдал их, банкны бизнес хийх туршлага бага, Төв банкны хяналтын тогтолцоо сул зэрэг олон шалтгаанаар 1990-ээд оны үед арилжааны банкууд дампуурч байв. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд 19 банк дампуурснаас сүүлийн 15 жилд 5 банк дампуурчээ.

1994 - 1995

- ММ инвест банк
- Их зам банк

1996

- Сэлэнгэ банк
- Төв ази банк
- Монгол хоршоо банк
- Ардын банк
- Даатгал банк

1998

- Эдийн тэнгэр банк
- Монголбизнес банк

1999

- Баянбогд банк
- Азийн хөрөнгө оруулалтын банк
- Сэргээн босголтын банк
- Экспорт, импорт банк
- ХОТШ банк






2006 - 2013

- Интербанк
- Анод, зоос банк
- Монгол шуудан банк
- Хадгаламж банк


2019

- Капитал банк


12. БАНКНЫ САЛБАРЫН СҮҮЛИЙН 15 ЖИЛИЙН ХАНДЛАГА




Чанаргүй зээлийн харьцаа




Депозит/ДНБ




Хадгаламжийн долларжилт




Зээл/депозит




Өөрийн хөрөнгийн өгөөж




Активын өгөөж




Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Зээл болон хадгаламжийн хүү



2008-2019 дундаж үзүүлэлт, улс орнуудтай харьцуулсан байдал





Хаяг: 2 давхар, Виста Оффис, Чингис Хааны өргөн чөлөө-17, Шуудангийн хайрцаг-101, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-13, Монгол Улс

Утас: 011 - 32 35 81

И-мэйл: info@mba.mn

Фэйсбүүк: [Mongolian Bankers Association](#)

Веб хуудас: www.mba.mn